

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

“Песо” хоршооны хадгаламж, зээлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 52 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 3 дугаар хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчсөн “Песо” хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Хорооноос хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, авсан арга хэмжээний талаар тайланг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Песо” ХЗХ /Н.Байгалмаа/-нд даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ